




УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлан

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт



Шилэн дансны тухай хуульд заасан байгууллагууд бүрэн хамрагдсан хэдий ч 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан зарим мэдээллүүдийг байршуулаагүй байна.

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн: Дарга бөгөөд тэргүүлэх аудитор М.Батсуурь Аудитын менежер М.Бат-Амгалан Ахлах аудитор Б.Авирмэд Аудитор Л.Бат-Очир 2017 оны 11 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 7045-3721, 70454721 дугаарын утсаар харилцана уу. Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангом сум 3 баг аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Товчилсон үгийн тайлал Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Ерөнхий зүйл Бүлэг 1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдсан байна. 3.2 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдсан байна. 3.3 Байгууллагууд шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталж ажилласан байна. Бүлэг 2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан зарим байгууллага, аж ахуйн нэгжүүд хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна. 2.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны зарим мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь тогтмол мэдээлээгүй байна. 2.2 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны зарим мэдээллийг 7 хоногийн дотор тогтмол мэдээлээгүй байна. 2.3 Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дансны мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь тогтмол мэдээлсэн үү? 2.4 Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа зарим компаниуд шилэн дансны мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь тогтмол мэдээлээгүй байна. 2.5 Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллага болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд хуульд заасан шаардлагын дагуу шилэн дансны зарим мэдээллийг байршуулаагүй байна. Бүлэг 3. Шилэн дансны хэрэгжилтэд тавих хяналт хэрэгжиж байна. 3.1 Хуулийн үйлчлэлд хамраарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна 3.2 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн хэдийч үр дүн нь хангалтгүй байна. 3.3 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын ажлын тайлан дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг тусгаагүй байна. 3.4 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны хөтлөлт, мэдээлэлтэй холбоотой санал, гомдол иргэдээс ирүүлээгүй байна.	5 6 8 9 9 11 11 11 12 13 13 13 14 14 15 16 16
--	--	--

	Бүлэг 4. Өмнөх аудитаар өгөгдсөн зарим зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	17
	4.1 Өмнөх аудитаар албан шаардлага өгөөгүй байна.	17
	4.2 Өмнөх аудитаар өгөгдсөн зарим зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	17
	Дүгнэлт	18
	Холбогдох байгууллагын санал	19
	Аудитын газраас өгөх тайлбар	21
	Зөвлөмж	22

Товчилсон үгийн тайлал:

1	ҮАГ	Үндэсний аудитын газар
2	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
3	НА	Нийцлийн аудит
4	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
5	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
6	ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
7	ТӨК	Төрийн өмчит компани

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөө, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Увс аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ.

Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан бүрэн хамрагдсан эсэх;
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх;
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх;

Аудитын хамрах хүрээ:

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээдийн 2016 оны 10 дугаар сарын 01-нээс 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болохуйц нотлох зүйлс, холбогдох бусад материалыг ажлын баримтад хавсаргав.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

1. Монгол улсын 2016 оны Төсвийн тухай хууль
2. Монгол улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль

3. Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хууль
4. Шилэн дансны тухай хууль
5. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
9. Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
10. Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

10. Аудит хийх хугацаа:

Нийцлийн аудитыг 2017 оны 10 дугаар сарын 18-наас 11-р сарын 20-ны хооронд ахлах аудитор Б.Авирмэд, аудитор Л.Бат-Очир нар хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий зүйл

Аудитыг батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан аудитын зорилт, дэд зорилтуудын хүрээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж байгаа эсэх, тэдгээр байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх, 8 дугаар зүйлийн 8.2-т заасан байгууллага, албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг авч үзлээ.

Увс аймгийн хэмжээнд төрийн өмчийн 36 төсөвт байгууллага, орон нутгийн өмчийн 141 байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 5, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 4 нийт 186 хуулийн этгээд 2017 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар shilendans.gov.mn сайтад бүртгэгдсэн байна.

Өмнөх аудит хийснээс хойш Худалдан авах ажиллагааны газар, Цөм сүргийн үржлийн төв татан буугдсан ба Малчин сумын Сум дундын ойн анги, Улаангом сумын 10-р цэцэрлэг шинээр байгуулагджээ.

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан нийт 166 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрыг хамрууллаа. 2015, 2016 онуудад хийсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүн, дүгнэлт, судалгаа, Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны эхний 9 сарын байдлаарх нэгтгэсэн мэдээллийг үндэслэн 20 байгууллагад итгэл үзүүлэв.

БҮЛЭГ 1

Шилэн дансны тухай хуулийн 3.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдсан байна.

1.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд”, 3.1.2-д “төрийн өмчит үйлдвэрийн газар”, 3.1.3-д “Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутгийн болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани энэ хуулийн үйлчлэлд хамаарна” гэж заасан байна.

Дээрх заалтыг үндэслэн 2017 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар Увс аймгийн хэмжээнд 186 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд shilendans.gov.mn сайтад бүрэн бүртгүүлж, мэдээллээ оруулсан байна.

Хуулийн үйлчлэх хүрээг графикаар үзүүлбэл дараах байдалтай байна.

Зураг-1



2015, 2016 онуудад хийсэн аудитын дүн, мэдээлэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанаас 2017 оны эхний 9 сарын байдлаар хийсэн нэгтгэсэн мэдээллийг үндэслэн 20 байгууллагад итгэл үзүүлэв.

Итгэл үзүүлсэн газруудыг хүснэгтээр харуулав. /Хүснэгт-1/

Итгэл үзүүлсэн байгууллагууд

Хүснэгт-1

№	Байгууллагын нэр	2015 оны аудитын дүн, мэдээлэл	2016 оны аудитын дүн, мэдээлэл	ТЕЗ-ийн аудитын албанаас 2017 оны эхний 9 сарын байдлаар хяналт хийсэн дүн
1	Прокурорын газар	+	+	+
2	Байгаль орчин аялал жуулчлалын газар	+	+	+
3	Гаалийн газар	+	+	+
4	Номын сан	+	+	+
5	Санхүүгийн хяналт аудитын алба	+	+	+
6	Стандарт хэмжилзүйн хэлтэс	+	+	+
7	Статистикийн хэлтэс	+	+	+
8	Татварын хэлтэс	+	+	+
9	Улсын бүртгэлийн хэлтэс	+	+	+
10	Цагдаагийн газар	+	+	+
11	Шүүх шинжилгээний алба	+	+	+
12	Хилийн цэргийн 0245-р анги	+	+	+
13	Эрүүл мэндийн газар	+	+	+
14	ХанХөхийн УТХГН-ын хамгаалалтын захиргаа	+	+	+
15	Баруунтуруун Улсын нөөцийн салбар	+	+	+
16	Увс Улсын нөөцийн салбар	+	+	+
17	Авто тээврийн үндэсний төв ТӨААТҮГ Увс аймаг дахь салбар	+	+	+
18	Музей	+	+	+
19	Зэвсэгт хүчний 328-р анги- Зүүнговь сум	+	+	+
20	Хилийн 0311-р цэргийн анги	+	+	+
Дүн		20	20	20

Тайлбар: + шилэн дансны мэдээллийг хангалттай байршуулсан.

Эх сурвалж:

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2015, 2016 онд хийсэн аудитын тайлан
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2017 оны эхний 9 сарын байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийсэн дүн

Шинээр байгуулагдсан Улаангом сумын 10-р цэцэрлэг, Малчин сумын Сум дундын Ойн анги shilendans.gov.mn сайтад цэс нээлгэж бүртгүүлжээ. Цөм сүргийн үржлийн төв татан буугдаж сайтаас хасалт хийлгэсэн байна.

1.2 Байгууллагууд шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталж ажилласан байна.

Увс аймагт үйл ажиллагаа явуулж буй шилэн дансны үйлчлэлд хамрагдах байгууллагууд shilendans.gov.mn сайтад бие даасан цэс нээлгэж мэдээллээ байршуулж байна. Харин Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан мэдээллийг байгууллагын дарга, нягтлан бодогч нар өөрчлөгдөхөд шинэчилж оруулаагүй байна. Тухайлбал:

- Татварын хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Боловсрол, соёл урлагийн газар, Хөгжимт жүжгийн театр, Биеийн тамир спортын газар, Шинэ Улаангом ОНӨААТҮГ, Дулааны 2-р станц дулааны шугам сүлжээ ОНӨААТҮГ, Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨК, Прокурорын газар, Улаангом сумын ИТХ, Ахлах 3-р сургууль гэх мэт

Тодруулга өгөх албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдолд шилэн дансны цахим хуудсанд нэр, утас, цахим хаягийг шинэчилж байхыг зөвлөмж болголоо.

Шилэн дансны үйлчлэлд хамрагдах байгууллагууд шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан мэдээллийг шинэчилж байгаа боловч хуулинд заасан цаглабарт хугацаанаас хоцроож байршуулах асуудал нийтлэг байна.

Аудитад хамрагдсан байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу шилэн дансны мэдээллийг мэдээллийн самбарт байршуулсан байна.

БҮЛЭГ 2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан зарим байгууллага, аж ахуйн нэгжүүд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

2.1 Зарим төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь тогтмол мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу 2017 оны 3-р улирлын байдлаар дараах мэдээллийг бүрэн оруулсан байхаар тусгасан байна. Үүнд:

- 6.1.1 Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01-дүгээр сарын 10-ны өдрийн дотор
- 6.1.2 хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;
- 6.1.3 дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;
- 6.1.4 жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;
- 6.1.5. төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 07-ны өдрийн дотор;
- 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр;

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан зарим байгууллагууд shilendans.gov.mn сайтад доорх мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна. Тухайлбал:

- 6.1.1-д заасан мэдээллээс тухайн жилийн батлагдсан төсвөө мэдээлээгүй 23, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөө мэдээлээгүй 33 байгууллага,
- 6.1.2-д заасан мэдээллийг 5 байгууллага,
- 6.1.3-д заасан мэдээллийг 37 байгууллага,
- 6.1.4-д заасны дагуу 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 72 байгууллага,
- 6.1.5-д заасан мэдээллээс аудитын дүгнэлтийг 76 байгууллага, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 51 байгууллага,
- 6.1.6-д заасан мэдээллээс төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгааны тайлбарыг 7 байгууллага тус тус мэдээлээгүй байна.

Хуулийн 3.1-д заасан байгууллагуудад 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлж байхыг зөвлөмж болгов.

Жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг мэдээлээгүй шалтгаан нь 2017 онд шилэн дансны сайтад байршуулах эрх үүсээгүйтэй холбоотой байна. Дээрх мэдээллүүдийг дараа жилийн 4 дүгээр сарын 25-ны дотор байршуулахаар хуулинд заасан боловч сайтад өмнөх оны эцэст байршуулах боломжтой байжээ. Тус асуудлыг Сангийн яаманд хандаж шийдвэрлүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөлөө.

2.2 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны зарим мэдээллийг 7 хоногийн дотор тогтмол мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан мэдээллийг аудитад хамрагдсан зарим байгууллагууд шилэн данс цахим хуудсанд бүрэн байршуулаагүй байна. Тухайлбал:

Хавсралт хүснэгт №1,2

- 6.4.1-д заасан мэдээллийг 10 байгууллага,
- 6.4.2-д заасан мэдээллийг 19 байгууллага тус тус мэдээлээгүй.
- 6.4.3-д заасан 85 байгууллагын тендерт оролцсон нийт 815 иргэн, аж ахуйн нэгжээс 190, шалгарсан 439 оролцогчоос 91, шалгараагүй 376 оролцогчоос 99 оролцогчийг, тус тус мэдээлээгүй байна.
- 6.4.4-д заасан 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2881.7 сая төгрөгийн 182 гүйлгээнээс 2544.3 сая төгрөгийн 158 гүйлгээг мэдээлж, 337.4 сая төгрөгийн 24 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.
- 6.4.5-д заасан 5 сая төгрөгөөс дээш зарлагын 7187.5 сая төгрөгийн 476 гүйлгээнээс 6357.7 сая төгрөгийн 404 гүйлгээг мэдээлж, 829.8 сая төгрөгийн 72 гүйлгээг мэдээлээгүй, Орлогын 45541.0 сая төгрөгийн 1459 гүйлгээнээс 41587.8 сая төгрөгийн 1241 гүйлгээг мэдээлж, 3953.2 сая төгрөгийн 218 гүйлгээг мэдээлээгүй байна.
- 6.4.6-д заасан мэдээллийг 19 байгууллага
- 6.4.7-д заасан мэдээллийг 8 байгууллага тус тус мэдээлээгүй байна.
- 6.4.8-д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 5739.3 сая төгрөгийн 2225 шийдвэрээс 645.8 сая төгрөгийн 390 шийдвэрийг мэдээлж, 5093.5 сая төгрөгийн 1835 шийдвэрийг мэдээлээгүй байна.
- 6.4.9-д заасан мэдээллийг 19 байгууллага мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан мэдээллийг байршуулаагүй байгууллагуудад зөрчлийг давтан гаргахгүй байхыг албан шаардлага болголоо.

2.3 Асуудлын шинжилгээний тус заалт аймаг дахь аудитын газарт хамааралгүй байна.

2.4 Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа зарим компаниуд шилэн дансны мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь тогтмол мэдээлээгүй байна.

Увс аймагт Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 5, төрийн болон орон нутгийн өмчит компани 4 нийт 9 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Таван тэсийн илч ОНӨААТҮГ газар шилэн дансны сайтад мэдээлэл огт байршуулаагүй, Дулааны 2-р станц, дулааны шугам сүлжээ ОНӨААТҮГ мэдээллээ хангалтгүй байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан мэдээллийг байршуулаагүй дээрх байгууллагуудад зөрчлийг давтан гаргахгүй байхыг албан шаардлага болголоо.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д заасан аж ахуйн нэгжүүдээс:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөө мэдээлсэн 7, мэдээлээгүй 2,
- худалдан авах ажиллагааны тайланг мэдээлсэн 5, мэдээлээгүй 4,
- 24 удаагийн тендерт 38 оролцогч оролцсон ба шалгарсан 24 ороцогчоос мэдээлсэн 14, шалгараагүй 14 үүнээс 9 ороцогчийг мэдээлсэн байна.

Чандмань-Увс ОНӨХХКомпани нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концессоор өмнө нь гүйцэтгэсэн ажлын дутуу санхүүжилт 788.2 сая төгрөгийн авлагыг сайтад мэдээлсэн байна.

2.5 Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллага болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд хуульд заасан шаардлагын дагуу шилэн дансны зарим мэдээллийг байршуулаагүй байна.

Аудитын хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс болон сумдын санхүүгийн албанаас хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа авч нэгтгэн үзэхэд улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 87 аж ахуйн нэгж байгууллага 2017.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж хэрэгжилт 96.2 хувийн биелэлттэй байна.

Дээрх 87 арга хэмжээнд өссөн дүнгээр 1866.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил,

үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага мэдээлэл байршуулахаар заасан ба эдгээр хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүд ямар нэг мэдээлэл байршуулаагүй. Харин санхүүжилт олгосон газрууд холбогдох мэдээллийг мэдээлсэн байна. /Хавсралт№4/

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 9 байгууллагад жилийн эцсийн гүйцэтгэлээр 738.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 607.7 сая төгрөгийг олгожээ. Үүнээс 3 байгууллагад олгосон 402.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс шилэн дансны сайтад мэдээлжээ. /Хавсралт №5/

Харин хувийн хэвшлийн 2 сургууль, 4 цэцэрлэгт олгосон 205.7 сая төгрөгийн санхүүжилтийг холбогдох сургууль, цэцэрлэгүүд нь шилэн дансны сайтад мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг цахим хуудсанд бүрэн байршуулахад чиглэсэн тодорхой арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд зөвлөмж болгов.

Бүлэг 3 Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналт хэрэгжиж байна.

3.1 Хуулийн үйлчлэлд хамраарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” гэж заажээ.

Төрийн аудитын байгууллага шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд жилд 1-2 удаа аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж өгч ажилласнаас гадна сум, байгууллагад гүйцэтгэл, нийцлийн аудит хийхдээ тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын ажлын алба 2017 оны ажлын төлөвлөгөөндөө сумдын ИТХ-ын дотоод үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ өгөхөөр тусгажээ. Үүний дагуу цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулсан санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг сумдын хурлын үйл ажиллагааны үнэлгээний нэг хэсэг болгон тусгаж, хяналт үнэлгээг хийж 2017 оны эхний 10 сарын байдлаар 82%-ийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Харин бусад албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавиагүй байна. Цаашид хурлын хороодоороо дамжуулан төсөв санхүүгийн ил тод байдалд үнэлгээ өгч иргэд олон нийтэд сурталчилахаар төлөвлөж байгаа гэсэн 2017 оны 11 сарын 08-ны өдрийн 273 тоот албан бичгийг аймгийн ИТХ-ын ажлын албанаас аудитын явцад ирүүлсэн.

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн ИТХ-д зөвлөмж болгов.

3.2 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн хэдий ч үр дүн нь хангалтгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.2-д “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Увс аймгийн засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хуулийн 3.1.1-д заасан байгууллагуудын shilendans.gov.mn сайтын мэдээллийг хянаж тухай бүр зөвлөмж өгч, арга зүйгээр ханган ажилласан байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс shilendans.gov.mn сайтад 2017 оны 2-р улирлын санхүүгийн тайлангаа хугацаанд нь байршуулаагүй улсын төсвийн 22 байгууллага болон 7 сумын 42 байгууллагад нөхөж байршуулах, холбогдох албан тушаалтанд арга хэмжээ авах албан тоот хүргүүлжээ. Үүний үр дүнд байгууллагууд мэдээллийг нөхөн байршуулсан ба 13 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.1.1, 6.1.5-д заасан мэдээллийг байршуулаагүй байгууллагуудад Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2017.10.23-ны өдрийн 23 тоот албан бичгийг хүргүүлж биелэлтийг хангуулахаар ажиллаж байна.

Шинээр байгуулагдсан Малчин сумын Сум дундын ойн анги, Улаангом сумын 10 дугаар Цэцэрлэгийн холбогдох материалыг Сангийн яамны цахим системийн төв админд хүргүүлж шинээр цэс нээлгэжээ.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас Шилэн дансны тухай хуулийг орон нутгийн телевизээр 2 удаа сурталчилж, uvs.gov.mn сайтад 2017 оны 2-р сар хүртэл мэдээлэл байршуулсан байна.

Улаангом сумын цэцэрлэгүүдийн холбогдох албан тушаалтнуудад Шилэн дансны тухай хуулийн сургалт хийж, 8 суманд ажиллахдаа шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж зөвлөгөө өгч ажиллажээ.

Нээлттэй хаалганы өдрийг 3 удаа зохион байгуулж 6 төрлийн сурталчилгааны материал, гарын авлагыг 40 гаруй иргэнд тараасан байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас дээрх арга хэмжээг авч ажиллаж байгаа хэдий ч аудитад хамрагдсан байгууллагууд мэдээллээ хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлээгүй байна.

Цаашид Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг цахим хуудсанд бүрэн байршуулахад чиглэсэн тодорхой арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд зөвлөмж болгов.

3.3 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын ажлын тайлан дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг тусгаагүй байна.

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан журамд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх заалт тусгагдаагүй байсан тул 2016 онд сум, байгууллагын ажлыг дүгнэхдээ шилэн дансны хөтлөлтийг харгалзаж үзээгүй гэсэн тайлбарыг аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга өгч байна.

Харин Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 89 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баталж өмнөх 322 дугаар тогтоолыг хүчингүй болгосон ба сум, байгууллагын ажлыг дүгнэхдээ шилэн дансны хөтлөлтийг харгалзан үзэхээр заасан байна.

Дээрх тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/281 тоот захирамж гарч “Сум, агентлагийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг шинэчлэн баталсан байна. Тус аргачлалд шилэн дансны хөтлөлтийг үнэлж байхаар тусгажээ.

Цаашид Сум, агентлагийн ажлыг дүгнэхдээ шилэн дансны хөтлөлтийг харгалзан үзэж байхыг аймгийн Засаг даргад зөвлөмж болгов.

3.4 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны хөтлөлт, мэдээлэлтэй холбоотой санал, гомдол иргэдээс ирүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Энэ хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдал болон шаардлагыг байгууллага, албан тушаалтан хүлээн аваагүй бол энэ талаарх гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу төрийн аудитын байгууллагад гаргах бөгөөд энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын үйл ажиллагаанд аудитын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргаж болно” гэж заажээ.

Дээрх асуудлаар Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2016 оны 10 дугаар сарын 01-нээс 2017 оны 10 дугаар сарын 01-ний хооронд иргэнээс ямар нэгэн өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлээгүй байна.

Увс аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Мэдээлэл технологи, өргөдөл гомдол, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтнээс тодруулга авахад нээлттэй утсаар болон бичгээр шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өргөдөл гомдол, мэдээлэл ирүүлээгүй гэсэн тайлбарыг өгөв.

Бүлэг 4 *Өмнөх аудитаар өгөгдсөн зарим зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.*

4.1 Өмнөх аудитаар албан шаардлага өгөөгүй байна.

4.2 Өмнөх аудитаар өгөгдсөн зарим зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

№	Өгөгдсөн зөвлөмж	Биелэлт	тайлбар
1	Шилэн данс цахим хуудсанд Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Орон нутгийн өмчийн алба, Худалдан авах ажиллагааны алба, Орон нутгийн өмчийн газар гэсэн давхар цэс нээсэн байгааг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх.	биелээгүй	Санхүүгийн хяналт аудитын албанаас Сангийн яаманд хандсан боловч шийдвэрлээгүй
2	Өрхийн эмнэлгүүдийн цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэл оруулах боломжийг хангах.	биелээгүй	
3	Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг цахим хуудсанд бүрэн байршуулах арга хэмжээг авах.	ахиц гарсан	
4	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу хяналтыг хийж биелэлтийг хангуулах.	ахиц гарсан	

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан нийт 186 төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, компани Шилэн дансны тухай хуулийн дагуу shilendans.gov.mn сайтад бүртгэгдсэн байна.
2. Зарим байгууллагын дарга, нягтлан бодогч өөрчлөгдсөн мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд шинэчлээгүй байна.
3. Аудитад хамрагдсан байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.
4. Шилэн дансны тухай хуулийн 3.1.2, 3.1.3-д заасан үйлдвэрийн газар, компаниудаас “Таван тэсийн илч” ОНӨААТҮГ мэдээлэл байршуулаагүй, Дулааны 2-р станц, дулааны шугам сүлжээ ОНӨААТҮГ мэдээллээ хангалтгүй байршуулсан байна.
5. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагуудад олгосон санхүүжилтийн мэдээллийг хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгүүд шилэн дансны сайтад мэдээлээгүй байна.
6. Аймгийн ИТХ, сумдын ИТХ-ын дотоод үйл ажиллагаанд хяналт хийхэд шилэн дансны хуулийн хэрэгжилтэд үнэлгээ өгсөн боловч бусад байгууллагуудад хөндлөнгийн хяналт хийгээгүй байна.
7. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын ажлын тайлан дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ шилэн дансны хөтлөлтийг харгалзан үзэх шийдвэр гарсан байна.
8. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны хөтлөлт, мэдээлэлтэй холбоотой санал, гомдол иргэдээс ирүүлээгүй байна.

Холбогдох байгууллагын санал**УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АЖЛЫН АЛБА**

213400, Улаангом сум, Увс аймаг
Регистр: 9062858,
Утас/факс: 70452214

2017. 11.20 № 288
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Дээрх аудитын дүгнэлттэй санал нэг байна. Бид цаашид тус хуулийн 3.1-д дурдсан байгууллага, эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хуулийн хүрээнд тавих хөндлөнгийн хяналтыг сумын ИТХ, багийн ИНХ-аар дамжуулан зохион байгуулах болно.

Хүндэтгэсэн,

ДАРГА

Х.ДАШЗЭВЭГ

01 203



**УВС АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
АУДИТЫН АЛБА**

213400, Увс аймаг, Улаангом
Утас: 7045-5570, 7045-2415

2017.11.20 № 32
танай _____ -ны № _____ -т

**АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Харъяалах байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудитын тайлан, дүгнэлттэй санал нэг байна. Өгсөн зөвлөмж үүргийг хэрэгжүүлж ажиллах болно.

Дарга



М.Энхболд

**Холбогдох байгууллагын ирүүлсэн
саналд өгөх тайлбар**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан аймгийн ИТХ-ын 288 тоот, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 32 тоот албан бичгүүдээр ирүүлсэн саналыг үндэслэн тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Э.Насанбат танаа:

1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх.

Аймгийн Засаг дарга Д.Батсайхан танаа:

1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 89 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж сум, агентлагийн ажлыг дүгнэхдээ шилэн дансны хөтлөлтийг харгалзан үзэж байх.
2. Шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга М.Энхболд танаа:

1. Тодруулга өгөх албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдолд шилэн дансны цахим хуудсанд нэр, утас, цахим хаягийг шинэчилж байх.
2. Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг цахим хуудсанд бүрэн байршуулахад чиглэсэн тодорхой арга хэмжээ авч ажиллах.
3. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д заасны дагуу тавих хяналтыг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохиох.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:
АУДИТОР:

Б.АВИРМЭД
Л.БАТ-ОЧИР

2017 оны 11 сарын 16